

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2023 он

АГУУЛГА

1.ХУРААНГУЙ ТАЙЛАН	4
2.БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ БОЛОН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА	8
2.1 ОРШИЛ	9
2.2 АРГА ЗҮЙ	16
2.3 БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА	19
3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД	22
4. ЗӨВЛӨМЖ	24
5. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	26

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

АДШЭЦХ	НАССР	Hazard Analysis Critical Control Point	Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт
БОНЗ	ESG	Environmental, Social, and Governance	Байгаль орчин, Нийгэм, Засаглал
БОННУ	ESIA	Environmental and Social Impact Assessment	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОМТ	EMP	Environmental Management Plan	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ЕХ	EU	European Union	Европын Холбоо
ЕХТБТС	ESRS	European Sustainability Reporting Standards	Европын Холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандартууд
ЕСТЗГ	EFRAG	European Financial Reporting Advisory Group	Европын Санхүүгийн Тайлагналын Зөвлөх Групп
БХХЭУЗ	UNGP BHR	United Nations' Guiding Principle on Business and Human Rights	НҮБ-ын Бизнесбахүний эрхийн удирдлагын зарчмууд
ТоС ХОЛБОО	MSFA	Mongolian Sustainable Finance Association	Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо
ТХЗ	SDG	Sustainable Development Goals	Тогтвортой Хөгжлийн Зорилгууд
КТБТС	CSRD	Corporate Sustainability Reporting Directive	Компанийн Тогтвортой байдлын тайлагналын тогтоол
ТОУС	GRI	Global Reporting Initiative	Тайлагналын Олон Улсын Санаачилга
ОУСК	IFC	International Finance Organization	Олон Улсын Санхүүгийн Корпораци
СЗХ	FRC	Financial Regulatory Commission	Санхүүгийн Зохицуулах Хороо
ХАБЭА	OSH	Occupational Safety and Health	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ЭМАА	H&S	Health and Safety	Эрүүл мэнд аюулгүй ажиллагаа
ЭЗХАХБ	OECD	Organization for Economic Cooperation and Development	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага

1. ХУРААНГУЙ ТАЙЛАН

“Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК нь “Увс Хүнс” ХК-ийн талх, нарийн боов, архи, чацаргана ундаа, ус, гурил, сүү, цагаан идээний хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) суурь үнэлгээг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

Энэхүү үнэлгээний ажил нь дараах үндсэн 6 алхмаас бүрдсэн.




Зураг 1. БОНЗ үнэлгээний ажлын алхмууд

Үнэлгээ хийхдээ НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ), Олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын түгээмэл мөрддөг Байгаль орчин, Нийгэм, Засаглалын шаардлагууд болох Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК): Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, Европын Холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандарт, конвенц, тунхаглал болон Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, журмуудад заасан шаардлагуудыг шалгуур болгон авч үзлээ. Мөн дараах хүчин зүйлүүдийн шаардлагаар БОНЗ-ын суурь үнэлгээнд мэргэжлийн байгууллагаар тодотгол хийлгэх шаардлагатай байдаг. Үүнд:

1. Санхүүжүүлэгч байгууллага
2. Хөрөнгийн биржийн стандарт шаардлага
3. Бизнесийн өөрчлөлт
4. Хууль эрхзүйн орчинд нэмэлт орох (бизнесийн үнэ цэнд нөлөөлөхүйц)
5. ТУЗ-ийн БОНЗ-ын хорооны санаачилгаар


6. Гүйцэтгэх удирдлагын санаачилгаар

БОНЗ-ын суурь үнэлгээг нийт 235 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд 132 шалгуур бүрэн биелсэн, 28 шалгуур бүрэн бус, 75 шалгуур биелээгүй байна. Өөрөөр хэлбэл 56.2% биелэлттэй байна (Зураг 2).



Зураг 2. БОНЗ-ын үнэлгээний дүн

БОНЗ-ын үнэлгээний шалгууруудыг нэгдсэн оноогоор (score) авч үзвэл нийт арван оноо авах ёстойгоос 5,8 оноо авсан байна.



Зураг 3. БОНЗ-ын үнэлгээний нэгдсэн оноо

“Увс Хүнс” ХК нь БОНЗ-ын хувьд арвин ололт амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

Үнэлгээний үр дүнгээс харахад “Увс Хүнс” ХК нь нийгмийн хариуцлагаа ухамсарлан, БОНЗ-ын хувьд арвин ололт амжилттай сайн дадалтай байна.

ОЛОЛТ АМЖИЛТ



ХАМТЫН ҮНЭ ЦЭНИЙГ БИЙ БОЛГОГЧ

Байгууллагын ёс зүйн соёл буюу хамтын (дундын) үнэ цэнийг ажиллагсад болон орон нутагтай хамтран бүтээж, хуваалцах зохицуулалт механизмыг бүрдүүлж, зөвхөн байгууллагын хүрээнд хязгаарлагдалгүй салбарын хэмжээнд түгээж манлайлж буй нь НҮБ-ын “Тогтвортой Хөгжлийн Зорилт 2030”-ын үндсэн зарчим болох “Хэнийг ч ардаа үлдээхгүй”-тэй нийцэж байна. Энэ нь итгэлцэл хүндлэл дээр суурилсан ажил хэрэгч хамтын ажиллагааны суурь болсон байна.

Мөн Увсын чацаргана газар зүйн заалт Европын Холбоонд бүртгэгдэх үйл ажиллагааг манлайлан зохион байгуулж орон нутгийн чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн орлого нэмэгдэх, тогтвортой бизнес эрхлэлтийг дэмжих, байгаль орчин, цаг уураас шалтгаалсан онцлог амт, чанарыг хадгалах, цаашлаад аялал жуулчлалын шинэ суваг бий болох, хэрэглэгч худалдан авагчид чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүн хэрэглэх зэрэг давуу талуудыг бий болгоход жимс жимсгэний салбарт түүчээлэн ажилладаг.



НИЙГЭМД ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛӨГЧ

Түүхий эдийн чанарын хяналтаар дамжуулж дотоодын жижиг дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд эрүүл ахуйн шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд, мөн бизнес эрхлэгчид борлуулалт, орлогоо урьдчилан тооцоолох улмаар дунд хугацааны төлөвлөгөө гаргах боломж бий болгож үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад эергээр нөлөөлж байна.



НИЙГМИЙН ОЛОН ТАЛТ, ЯЛГААТАЙ БАЙДЛЫН ОРОЛЦОО, ТЭГШ БОЛОМЖИЙГ ХАНГАГЧ

Өрх толгойлсон эмэгтэйчүүд, ахмад насныхан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажиллахад таатай ажлын байр бий болгож тэдний өрхийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна, нийгэмд өөрийн байр суурийг хадгалах, нийгмийн идэвхитэй гишүүн байх боломжийг бүрдүүлж байна. Энэ нь нийгмийн олон талт, ялгаатай байдлын оролцоог нэмэгдүүлэх, тэгш боломжийг хангахад оруулж буй том хувь нэмэр юм.



БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЭМЛЭГЧ



Үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүтээлчээр эрэлхийлж, хог хаягдлын менежментийг

сайжруулах, байгалийн нөөцийг зөв зохистой хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч ажилладаг. Уур амьсгалын өөрчлөлтийн хүчин зүйл болох хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад хувь нэмэрээ оруулж ажиллаж байна.

САЙЖРУУЛАХ БОЛОМЖУУД

Компанийн БОНЗ-ын гүйцэтгэлийг цаашид улам сайжруулах дараах боломжууд байна.

1. Байгаль орчин, нийгэм, засаглалын гүйцэтгэлийн тогтолцоог нэвтрүүлж, хэвшүүлэх
2. Уур амьсгалын өөрчлөлт болон хаягдалгүй эдийн засаг, тогтвортой худалдан авалтын бодлого боловсруулж, зорилт тодорхойлох, түүний дагуу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх

2.БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ БОЛОН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА




2.1 ОРШИЛ

Техник технологи, инновацийн хурд нэмэгдэхийн хэрээр бизнесийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл эрчимжсээр байна. Мөн түүнчлэн, хөрөнгө оруулагч болон санхүүжүүлэгч байгууллагын зүгээс бизнесийн тогтвортой байдлын харилцан үйлчлэл бүхий үндсэн хүчин зүйл болох бизнесийн ашигт ажиллагаа ба ёс зүйд онцгой анхаарал хандуулснаар байгууллага урт хугацаандаа зөвхөн хувь нийлүүлэгчдэд төдийгүй нийгэмд үнэ цэн бий болгох стратегийн чухал алхам хийх шаардлага гарч ирж байна. Иймд бизнесийн үйл ажиллагаанаас үүсэж буй аливаа нөлөөллийг авч үзэх, удирдах, хянах механизмийг бүрдүүлж, Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) гүйцэтгэлийг тодорхой, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтээр хэмжих, хянах, ил тод нээлттэй тайлагнах шаардлага урган гарсан.

БОНЗ нь өртгийн сүлжээний үнэ цэн нэмэх үйл ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг биш боловч хурдацтай өөрчлөгдөж буй гадаад орчны эрсдэл ба боломжийг үнэлэн, удирдах замаар урт хугацаанд бизнесийн тогтвортой байдлыг хангаж, үнэ цэнийг бүтээх чадавхийг бүрдүүлэхэд гол хөшүүрэг болдог. БОНЗ-ын гүйцэтгэлийг сайжруулах, тайлагнах механизм нь сайн дурын шинжтэй сэдэвчилсэн байдалтай эхэлсэн боловч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүрээгээ улам тэлж, баяжин, хариуцлага өндөрсөж иж бүрэн тогтолцоо болон хөгжиж байгааг тайлагнал, судалгааны олон байгууллагуудын зааварчилгаа, удирдамж, зөвлөмжүүд нотлож байна.

Тухайлбал, компанийн нийгмийн хариуцлагын тайлагналд тухайн байгууллага нь бизнесийн гүйцэтгэлтэйгээ уялдаа сул, ихэвчлэн сайн дурын шинжтэй түр хугацааны санаачилга төдий, эсвэл баримт бичгийн хүрээнд тунхаг-хэлбэрийн шинжтэй, пи-ар буюу сурталчилгаа төдийгөөр тайлагнах байдал нийтлэг байдаг. Харин БОНЗ тайлагнал нь байгууллагын бизнесийн үр өгөөж, үнэ цэнийг өсгөх санхүүгийн бус тайлагналын гол хөшүүрэг учраас БОНЗ-ын багц стандартын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь


БОНЗ ТӨЛӨВШИЛИЙН ЗАМНАЛ



Зураг4. БОНЗ-ын төлөвшилийн замнал

удирдлагын багийн жилийн үүрэг амлалт, зорилтын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж, баг хамт олны олон талт ялгаатай байдал, ижил тэгш боломж, оролцоог чухалчилж, хариуцлагыг сайжруулж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг эрхэмлэх замаар хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч болон бусад оролцогч талуудын итгэл хүлээсэн таатай орчинг бүрдүүлснээр “НЭЭЛТТЭЙ ТҮНШЛЭЛ, ДУНДЫН ЭКОСИСТЕМ, ХАМТЫН ҮНЭ ЦЭН”-ийг бүтээх гол механизм болдог.


БОНЗ нь тухайн байгууллагын дотоод ба гадаад орчинд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх багц шалгууруудаас бүрддэг.



Иймд тухайн байгууллага *Зураг 5. БОНЗ-ын жишээ шалгуур үзүүлэлт* БОНЗ-ын шалгуурыг хангасан "нийгмийн хариуцлагатай, ёс зүйтэй" хөрөнгө оруулалтын стратегийг хэрэгжүүлснээр, хөрөнгө оруулагчдын итгэлийг олж, санхүүжилт татах боломжийг нэмж, бизнесийн үр өгөөж, үнэ цэнийг өсгөх найдвартай орчин бүрддэг юм.

2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Европын Санхүүгийн Тайлагналын Зөвлөх Групп (ЕСТЗГ) нь Европын Холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандартыг (ЕХТБТС) олон талт хэлэлцүүлэг хийж зөвлөлдсөний үндсэн дээр баталгаажуулсан. Тухайн стандартуудаар бизнесийн байгууллагуудаас байгаль орчин, нийгэм, засаглалтай холбоотой мэдээллүүдийг олон нийтэд нээлттэй байдлаар тайлагнах шаардлагуудыг тодорхойлсон бөгөөд Европын Холбооны (ЕХ) парламентын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Компанийн Тогтвортой байдлын тайлагналын тогтоолын (КТБТТ) нэг бүрэлдэхүүн хэсэг болж хэрэгжих юм.

Европын Холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандарт (ЕХТБТС) нь ерөнхий зарчим, тайлагналын ерөнхий шаардлага буюу стратеги, удирдлага, давхар материаллаг нөлөөллийн үнэлгээ, болон байгаль орчин, нийгэм, засаглалын сэдэвчилсэн шаардлагуудын нэгдлээс бүрддэг. Салбарын болон бичил, жижиг, дунд бизнесийн үйл ажиллагааны онцлог нөхцөл байдалд нийцүүлсэн стандартууд нь боловсруулагдаж хараахан дуусаагүй байна.




Зураг 6. Тогтвортой байдлын тайлагналын стандартуудын уялдаа холбоо

Эдгээр стандартууд нь 2024 оноос эхлэн шаталсан байдлаар мөрдөгдөж эхлэх бөгөөд ЕХ-ны улсууд, үндэстэн дамнасан корпорациуд болон ЕХ-ны зах зээл дээр бизнес хийх зорилго бүхий гадаадын аж ахуйн нэгжүүдэд хамаарна.

ЕХ-ны Тогтвортой байдлын тайлагналын стандартын шаардлагын дагуу БОНЗ-ын тайлан боловсруулах дарааллын хувьд:

1. Үйл ажиллагаандаа (өөрийн болон өртгийн сүлжээнд) тогтвортой байдлын эрсдэлийн магадлан шинжилгээ хийж БОНЗ-ын төлөв байдлыг тодорхойлох;
2. Оролцогч талуудын хамтын чармайлтаар давхар материаллаг нөлөөллийн эрсдэл тодорхойлох;
 - а. Бизнес төлөвлөх байдал
 - б. Оролцогч талд нөлөөлөх байдал
3. Ноцтой хор уршигтай, өндөр эрсдэлтэй, даамжрах магадлалтай асуудлуудыг тодорхойлж, тэдгээр эрсдэлийг хянан удирдах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
4. БОНЗ-ын тайлан боловсруулж, олон нийтэд нээлттэй мэдээлэх;



Зураг 7. БОНЗ-ын тайлах боловсруулах үе шат

“Ризилиенс Консалтинг Сервиз”ХХК нь энэхүү төслийн хүрээнд БОНЗ-ын тайлагналын эхний 2 үе шатны буюу бизнесийн өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж тайланг боловсруулсан болно. Цаашид тухайн бизнесийн байгууллага нь давхар материаллаг нөлөөллийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн, олон нийтэд нээлттэй тайлагнаж болно.

БОНЗ-ын төгөлдөршил нь дараах үндсэн 3 хүчин зүйлээр тодорхойлогдоно.

✓Бизнес бодитоор нөлөөлөх байдал/Materiality

Байгууллагын өсөлт, санхүү, хөрөнгө оруулалтын өгөөж, тогтвортой байдал болон хөрөнгө оруулагч ба бусад оролцогч талуудын ашиг сонирхол, итгэлд нөлөөлөх БОНЗ-ын үндсэн үзүүлэлтийг тодорхойлж, удирдаж, хянах процесс;


✓Эрх зүй/Regulation

Үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичиг, конвенцийн нийцлийг хангах; Жишээлбэл, 2015 онд Фольксваген компани Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийг үл тоомсорлон 11 сая дизель хөдөлгүүртэй автомашиныг хүлэмжийн хийн ялгарлын туршилт хэмжилт хийлгүйгээр худалдаанд гаргаснаар 27.4 тэрбум еврогийн торгууль шийтгэл авсан байна (*Corporate Finance Institute*®);

✓Ил тод байдал/Transparency

Үйл ажиллагааны (хөрөнгө оруулагчийн мөнгөний зарцуулалт, удирдлагын тухай) мэдээллийн ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагнах, тухайлбал, санаатайгаар аливаа мэдээллийг нуун дарагдуулахгүй байх соёлыг хэвшүүлсэн байх;

БОНЗ-ын тогтолцоог байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж, гүйцэтгэлийг хангаж ажиллах нь байнга давтагдан сайжирдаг процесс бөгөөд дараахь 6 алхмыг түгээмэл ашигладаг.



Зураг 8. БОНЗ-ын тогтолцоог нэвтрүүлэх 6 алхам

Олон улсын Хөрөнгийн бирж болон хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч байгууллагууд БОНЗ-ын тайлагналын багц стандартыг нэвтрүүлж, үйлчлүүлэгч/харилцагч талтай хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах процесс үргэлжилж байна.



2020 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Дэлхийн Тогтвортой хөгжлийн тайлагналын 5 байгууллага Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тайлагналын ажлын хэсгийн санаачлага (Task Force on Climate-related Financial Disclosures (TCFD))-н хүрээнд БОНЗ-ын

тайлагналын нэгдсэн стандартыг нэвтрүүлэхээр санал нэгдсэн. (*Statement of Intent to Work Together Towards Comprehensive Corporate Reporting, Facilitated by the Impact Management Project, World Economic Forum and Deloitte, September, 2020*). Үүнд:

“Ernst & Young” (EY) судалгааны байгууллагаас 2021 оны 12 дугаар сард танилцуулсан “Eight Global Corporate Reporting Survey”, “EY 2021 Institutional Investor Survey” зэрэг тайлангуудад дурдсанаар “Судалгаанд хамрагдсан хөрөнгө оруулагчдын тэн хагас нь материаллаг (санхүүгийн) асуудлуудаас илүү БОНЗ-ын тайлагнал илүү анхаардаг гэсэн бол эсрэгээрээ компанийн санхүүгийн удирдлагуудын 38% нь сорилт гэж үзсэн” байна.

2022 оны тус тайлангуудад нийт 1040 компанийн санхүүгийн захирлууд оролцсон бөгөөд ирээдүйн компанийн тайлагналд 3 үндсэн асуудал чухлыг онцолсон байна. Үүнд:

Хүснэгт 1. Тайлагналын үндсэн асуудлууд

1. Тогтвортой байдал болон урт хугацааны үнэ цэн нь компаниуд болон хөрөнгө оруулагчдын хоорондын харилцааг тасалдаг	
Хөрөнгө оруулагчид:	Компаниуд:
Хөрөнгө оруулагчдын зүгээс 78% нь компаниуд тэдний ашиг нь буурсан ч үйл ажиллагаатай нь хамааралтай БОНЗ-ын хүрээний асуудлуудад анхаарч хөрөнгө оруулалт хийх ёстой;	Компаниудын санхүүгийн захирлуудын зүгээс 55% нь компаниуд өөрсдийн үйл ажиллагаатай хамааралтайгаар БОНЗ-ын хүрээний асуудлуудыг богино хугацааны санхүүгийн гүйцэтгэл ашигт нөлөөлдөггүй ч гэсэн тэдгээрийг анхаарч авч үзэх
Хөрөнгө оруулагчдын 80% нь маш олон компаниудын хувьд “Тогтвортой байдлыг хангахад урт хугацааны хөрөнгө оруулалт татах үндэслэлийг оновчтой тайлбарлаж чадахгүй байгаа нь хөрөнгө оруулагчдад хүндрэл учруулж болзошгүй”;	Том компаниудын 53% нь “Хөрөнгө оруулагчдын зүгээс ирдэг богино хугацаанд ашиг хүртэх дарамт нь бидний урт хугацааны тогтвортой байдлын санхүүжилтэд асуудал учруулж байна”, санхүүгийн захирлуудын хувьд 20% нь “хөрөнгө оруулагчид улирлын ашигт голчлон анхаарч, тогтвортой байдал гэх зэрэг урт хугацааны хөрөнгө оруулалтад ач холбогдол багатай ханддаг”
2. Компанийн тайлагнал нь хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудтай илтгэлцлийг бий болгох Түлхүүр болдог	
<ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулагчдын 99% нь компаниудын БОНЗ-ын үнэлгээг анхаардаг бөгөөд, 74% нь үнэлгээг нь илүү албан ёсны байх ёстой гэсэн хандлагаар авч үзсэн Хөрөнгө оруулагчдын 73% нь компаниуд санхүүгийн болон БОНЗ-ын тайлагналыг боловсронгуй болгох тал дээр компаниуд бүтэлгүйтдэг нь бидний шийдвэр гаргалтад нөлөөлдөг Хөрөнгө оруулагчдын 76% нь компаниудын хөрөнгө оруулагчдад бэлтгэн гаргаж өгч буй мэдээлэл нь “ногоон угаалт” ын эргэлзээг нэмдэг 	
3. Компаниуд тайлагнал хийхдээ оролцогч талуудын хамтын чармайлтад түшиглэж чухалчлан үзэх асуудлууд	

Төвлөрөн анхаарах:

- БОНЗ-ын бусад чухал зорилтуудаас гадна компаниуд хөрөнгө оруулагчдад өөрсдийн багцаа хүлэмжийн хийг “Тэглэх” зорилттой уялдуулж, шилжилтийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтийн бодит эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтийн хувилбарын дүн шинжилгээ зэрэг чухал боломж, эрсдэлүүдийн талаар баттай ойлголттойгоор хариу өгөх ёстой,

Хариуцлага:

- Тогтвортой байдлын хүрээнд хөрөнгө оруулагчдын шаардлагыг Засаглал болон ТУЗ-ийн хяналтад хэрэгжүүлэх,
- БОНЗ-ын амлалт төдий бус илүүтэй үр дүнд суурилсан хэрэгжилтэд түлхүү анхаарч, хөрөнгө оруулагч ба компанийн хамтын чармайлтыг тогтмолжуулах,

Ил тод байдал:

- Компаниуд хөрөнгө оруулагчдад харьцуулж болохуйц, баталгаатай тогтвортой байдлын тайланг боловсруулах,
- БОНЗ-ын тайлагналын мэдээллийн чанарыг нэмэгдүүлж “GLOBAL REPORTING STANDART”-н шаардлагыг хангахын төлөө чармайх.

Ухаалаг:

- Гадаад болон дотоод мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээллийн эх сурвалжид хандах боломжийг олгох, дэвшилтэт технологи дээр суурилсан (AI) шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх,

Хүрэлцэхүйц:

- Санхүүгийн үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд “дараагийн түвшинд” загварчлах,
- Байгууллагын зорилгыг (хашаанаас давж) илүү өргөн хүрээнд тодорхойлсноор аливаа өөрчлөлт тогтворгүй байдалд илүү динамик, уян хатан хариу үйлдэл үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Авьяасаар манлайхуй:

- Компаниуд уламжлалт санхүүгийн тайлагналын мэдлэг, хандлагаар хязгаарлагдалгүйгээр өөрчлөгдөж буй эрэлт, хэрэгцээг хангахад шаардагдах чадавхыг бий болгохын тулд илүү шинэлэг үнэ цэнд суурилсан, хүнийг хүндэлсэн соёлыг бий болгох.

2.2 АРГА ЗҮЙ

2.2.1 ХАМРАХ ХҮРЭЭ

“Увс Хүнс” ХК-ийн талх, нарийн боов, архи, чацаргана ундаа, ус, гурил, сүү, цагаан идээний хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд Байгаль орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) суурь үнэлгээг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.

2.2.2 ҮНЭЛГЭЭНИЙ БАГ

“Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК нь 2020 онд Тогтвортой хөгжлийг дэмжих төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгжүүдэд Тогтвортой хөгжлийн зөвлөгөө өгөх чиглэлээр байгуулагдсан компани юм.

БОНЗ-ын суурь үнэлгээ хийх багийн ахлагчаар БОНЗ зөвлөх М.Сарандаваа, багийн гишүүнээр БОНЗ зөвлөх Др. Т.Индра, БОНЗ зөвлөх Ц.Нямгарав, зөвлөх Д.Эрдэнэхүү, зөвлөх М.Орхонтуул, зөвлөх Д.Нарантуяа, судалгааны ажилтан П.Мөнхзул, туслах ажилтан М.Дулаанжаргал, С.Молор нар ажилласан.

Манай зөвлөхүүдийн Байгаль орчин, нийгэм, засаглалын менежментийн чиглэлээр хийсэн ажлын туршлагаас дурьдвал:

- “М Си Эс Групп”-ын “Юнисервис Солюшн” ХХК-ийн үйл ажиллагаанд БОНЗ-ын суурь үнэлгээг хийж боловсруулсан.
- “Премиум Групп”-ын “Сентрал Экспресс Си Ви Эс” ХК-ийн СУ сүлжээ дэлгүүрүүд, түгээлтийн төв, хоол боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд БОНЗ-ын суурь үнэлгээг хийж боловсруулсан.
- Mongolian Mining Corporation нь Хонконгийн хөрөнгийн бирж дээр 2010 онд хувьцаа гаргасан бөгөөд тус төслийн IPO баримт бичгийн нийгэм болон байгаль орчны хэсгийг боловсруулсан.
- Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) санхүүжилтэд тавих үндсэн шаардлагын хүрээнд Ухаа худаг коксжих нүүрсний уурхайн (УНГ) I ба II үе шатны үйл ажиллагааны Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОНБҮ) тайлан, менежментийн төлөвлөгөөг боловсруулж амжилттай хэрэгжүүлсэн.
- ОУСК-ын Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн стандартын (2012) дагуу Оюу Толгой төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОНБҮ) тайлан, менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсэн.
- Таван Толгойн зүүн Цанхийн ордын үйл ажиллагаанд зориулж Хонконгийн Хөрөнгийн Биржээс санхүүжилт босгох ажлын хүрээнд төслийн БОНЗ-ын үнэлгээ хийх ажилд оролцсон.
- Энержи Ресурс ХХК-ийн БОХАБЭА менежментийн тогтолцоог бий болгосон.
- Манай зөвлөхүүд ISO 9001, ISO 14001, ISO22000 ба ISO / PAS 45005 стандартын аудиторууд бөгөөд ISO 9001, ISO 14001, ISO45001, Хөдөө аж ахуйн зохистой дадал /ХААЗД/ стандартуудын зөвлөгөө өгөх, аудит хийж байсан туршлагатай.

2.2.3 ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

БОНЗ-ын үнэлгээнд НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилгууд (ТХЗ), Олон Улсын Санхүүгийн Корпорацын (ОУСК) Байгаль орчин, Нийгэм, Засаглалд тавигддаг гүйцэтгэлийн шалгуурууд, конвенци, тунхаглал болон Монгол улсын холбогдох хууль, журам стандартуудын шаардлагуудыг шалгуур болгон авч үзлээ. Үүнд:

- *Монгол Улсын Үндсэн Хууль*
- *Иргэний хууль*
- *Компанийн тухай хууль*
- *Авлигын эсрэг хууль*
- *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль*
- *Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)*
- *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль*
- *Хүнсний тухай хууль*
- *Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль*
- *Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд*
- *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль*
- *Автотээврийн тухай хууль*
- *Байгууллагын нууцын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын тухай хууль*
- *Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль*
- *Оюуны өмч, патентийн тухай хууль*
- *Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль*
- *Өрсөлдөөний тухай хууль*
- *Үнэт цаасны тухай хууль*
- *Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль*
- *Технологи дамжуулах тухай хууль*
- *ОУСК: Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт 1,2,3,4 (2012)*
- *ОУСК-ын Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт удирдамж, стандарт (2021)*
- *НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал*
- *НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдлагын зарчим*
- *НҮБ-ын Сайн засаглалын зарчим (2009)*
- *ЕХ: Тогтвортой байдлын тайлагналын стандарт(ESRS 2022)*
- *ЕХ: Ногоон таксономи*
- *ЭЗХАХБ-аас гаргасан Компанийн засаглалын зарчим (2004)*
- *Тайлагналын Олон улсын санаачилгын стандартууд*
- *ТоС Холбоо: Ногоон таксономи*
- *СЗХ: Компанийн засаглалын кодекс*
- *СЗХ: Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам*
- *СЗХ: Компанийн засаглалыг үнэлэх үнэлгээний асуулга*

2.2.4 ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл, нотлох баримт цуглуулахдаа дараах арга зүйг ашигласан. Үүнд:

- Ярилцлага
 - Увс аймгийн захиргаа, Хөдөлмөр нийгэм халамжийн газар
 - 3 бэлтгэн нийлүүлэгч ААН
 - Засаглал, хүний нөөц, чанар, ХАБЭА, худалдан авалт, маркетинг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтнууд,
- Газар дээр ажиглалт
 - Хүнсний үйлдвэр
 - Нэрийн барааны дэлгүүр
 - Түгээлтийн үйл ажиллагаа
- Баримт бичгийн судалгаа
 - Хавсралтад тусгагдсан баримт мэдээллүүд
- Өгөгдлийн судалгаа
 - 285 үйлчлүүлэгчийн судалгаа

Цугларсан нийт өгөгдөл мэдээлэлд нийгэм, засаглал, байгаль орчны үнэлгээ, дүн шинжилгээг хийсэн болно.

ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ:

“Увс Хүнс” ХК-ийн БОНЗ-ын үнэлгээг боловсруулахдаа Монгол улсын хууль тогтоомж болон холбогдох дүрэм журмууд, ЕХ-ноос баталсан Ногоон Таксономи удирдамж, ЕХ-ны Тогтвортой байдлын тайлагналын стандарт (ESRS 2022), Тайлагналын олон улсын санаачилгын стандартууд (GRI), ОУСК-ын Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт удирдамж (Гүйцэтгэлийн стандарт) (2021), Монголын Тогтвортой Санхүүгийн Холбооны (ТоС Холбоо) Ногоон Таксономи удирдамжуудийн хүрээнд эх сурвалжуудын аргачлал, удирдамжийг үндэслэл болгож салбар тус бүр дээр дор дурдсан баримт бичгүүдийг ашигласан болно.

Байгаль орчин:

- ОУСК: Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандартууд (2012)
- ОУСК-ын Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт удирдамж, стандарт (2021)
- Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль тогтоомжууд

Нийгэм:

- Хөдөлмөрийн хууль
- Хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлын хууль
- Хүнсний тухай хууль
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт #2 Хөдөлмөр эрхлэлт ба ажлын нөхцөл
- НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал

- ISO45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандарт
- ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандарт

Засаглал:

- Компанийн тухай хууль
- НҮБ-ын Сайн засаглалын зарчим (2009)
- НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдлагын зарчмууд
- ОУСК-ын Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт удирдамж (Гүйцэтгэлийн стандарт) (2021)
- ЭЗХАХБ-аас гаргасан Компанийн засаглалын зарчим (2004)
- Компанийн засаглалын кодекс (2022)
- Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам (2022)

ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ, ЗАРЧИМ, БИЕЛЭЛТ:

- Тухайн шалгуурт харгалзах шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж тогтсон бол БҮРЭН,
- Тухайн шалгуурт харгалзах шаардлагыг баримт бичгийн хэмжээнд тусгаж, үйл ажиллагаандаа хараахан хэрэгжүүлээгүй бол БҮРЭН БУС,
- Тухайн шалгуурт харгалзах шаардлагыг хэрэгжүүлэх талаар тодорхой зүйл хийгдээгүй бол БИЕЛЭЭГҮЙ гэж тус тус үнэлсэн.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Анх 1941 онд БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчдийн 31-р тогтоолоор орон нутагт Хүнсний үйлдвэр байгуулах шийдвэр гарсны дагуу үр тариа, хүнсний ногоо тариалж, мал өсгөх, гурилан ба сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр Идэш тэжээлийн яамнаас Доржсүрэн гэдэг хүнийг Увс аймагт ирүүлж 1942 оны 2 дугаар сарын 18-ны өдөр “Идэш тэжээлийн комбинат” байгуулагдсанаар одоогийн “Увс Хүнс” ХК-ийн суурь тавигдсан юм. 1992 онд 51% нь төрийн өмчид, 49% нь нийтэд хувьчлагдсан “Чандмань” ХК болон өмчлөлийн хэлбэр өөрчлөгдсөн байна. 1997 онд Төрийн өмчийн хорооноос нийтийн дуудлага худалдаагаар төрийн өмчид байсан 51 хувийг хувьчилсан ба энэ үеэс “Увс Хүнс” ХК болон нэрээ өөрчилжээ.

2005 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс хувьцааны хяналтын багцыг шинэ хувьцаа эзэмшигчид худалдан авснаар компанийн гүйцэтгэх удирдлага бүрэн шинэчлэгдсэн бөгөөд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан орчин үеийн менежментийн арга хэлбэрийг амжилттай нэвтрүүлснээр үйл ажиллагаа жигдэрч мэргэжлийн боловсон хүчин авч ажиллуулан цаашид өргөжин дэвжих бололцоог бүрдүүлсэн байна. 2007 оноос UFC групп болон өргөжсөн ба 2013 оноос хувьцаагаа салгаж “Увс Хүнс” ХК нэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд талх, нарийн боов, архи, чацаргана ундаа, ус, гурил, сүү цагаан идээ гэсэн 7 төрлийн хүнсний үйлдвэрлэлийг орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийг уламжлалт технологитой хослуулан үйлдвэрлэл явуулдаг.



Зураг 9. “Увс Хүнс” ХК

Хүнс, гоо сайхны үнэт түүхий эд болох элит сортын чацаргана жимсийг Увс аймгийн Улаангом суманд 100 га талбайд тариалан чацарганы бүтээгдэхүүний гол түүхий эд бэлтгэн авч байгаа бөгөөд Монгол улсын оюуны өмчийн газраас “УВСЫН ЧАЦАРГАНА” газарзүйн заалтыг батлуулан эзэмшдэг.



2015 онд чацарганы үрнээс тос ялган авах CO₂ тоног төхөөрөмжийг Тайвань улсаас худалдан авч Монгол улсдаа анх удаа CO₂ экстрактын аргаар чацарганы үрийн тосыг гарган авч дотоодын зах зээлд борлуулж байна.

“Увс Хүнс” ХК нь үйл ажиллагаандаа ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 22000:2018 Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартыг, элит сортын чацаргана жимсний талбайдаа GLOBAL G.A.P Хөдөө аж ахуйн зохистой дадал стандартыг тус тус нэвтрүүлж олон улсын баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулсан.

Дотоод хяналтын лабораторид MNS ISO 17025:2018 стандартыг нэвтрүүлж хэрэглэгчидээ найдвартай эрүүл хүнсээр хангах эрхэм зорилгоо биелүүлэн ажилладаг.

Компани нь орчин үеийн бизнесийн арга туршлагыг байнга хөгжүүлэн ажиллаж дараах нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн хэрэглэгчиддээ хүргэж байна. Үүнд:

- Архин бүтээгдэхүүн 4 төрөл
- Чацарганы 5 нэр төрөл
- Цэвэр ус
- Гурилан бүтээгдэхүүн 50 гаруй төрөл
- Буудайн гурил, хивэг
- Арвайн гурил
- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж Монгол улсын хэмжээнд хэрэглэгчидээ эрүүл чанартай, хүнсээр хангаж байна.

Алс баруун хязгаарт үйл ажиллагаа явуулдаг “Увс Хүнс” ХК нь экологийн цэвэр нөөцийг дэвшилтэт технологиор боловсруулан эрүүл хүнсийг бүтээж хэрэглэгчдэд хүргэх эрхэм зорилгоо биелүүлэхийн зэрэгцээ жилдээ Монгол улсын төсөвт 1 орчим тэрбум төгрөгийн татвар оруулж байгаа нь бүс нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, хүн амыг эрүүл, найдвартай, дотоодын хүнсээр хангах үйл хэрэгт бодитой хувь нэмэр болж байгаа бөгөөд цаашид ОХУ, БНХАУ, БНСУ, Тайвань улс, Япон улс болон ЕХ-ны орнуудад өөрийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахаар зорьж байна.

3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД



Компанийн хэрэгжүүлж буй байгаль орчин, нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтэд хувь нэмэр оруулж байна. Үүнд:

- ✓ ТХЗ 1. Ядуурлыг устгах
- ✓ ТХЗ 3. Эрүүл мэндийг дэмжих
- ✓ ТХЗ 5. Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах
- ✓ ТХЗ 6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах

- ✓ ТХЗ 8. Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох
- ✓ ТХЗ 9. Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх
- ✓ ТХЗ 10. Тэгш бус байдлыг бууруулах
- ✓ ТХЗ 11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
- ✓ ТХЗ 12. Хариуцлагатай хэрэглээг дэмжих
- ✓ ТХЗ 13. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
- ✓ ТХЗ 16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох

БОНЗ-ын гүйцэтгэлийг сайжруулснаар ТХЗ-ын хэрэгжилтэд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.



Зураг 24 . Байгууллагын үйл ажиллагаа ТХЗ-той уялдсан байдал

4.3ӨВЛӨМЖ

БОНЗ-ын суурь үнэлгээний үр дүнд үндэслэн илэрсэн үл тохирлыг арилгах, БОНЗ-ын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг (Хүснэгт 13) боловсруулав.

Хүснэгт 13.Зөвлөмж

ОЙРЫН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

БАЙГАЛЬ ОРЧИН

- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар бодлого тодорхойлох (тусгайлсан эсвэл бусад журамд нэгтгэх байдлаар);
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл болон боломжийн талаар үнэлгээ хийж эрсдэлийг бууруулах, дасан зохицох арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэх;
- Компанийн шууд (Score 1) болон шууд бус (Score 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн нийт ялгарал (метр тонн CO₂-экв) тооцох өгөгдлийн мэдээллийн сан үүсгэх, тооцоолол хийх;
- Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний үр дүнд бууруулсан нүүрсхүчлийн хийн ялгарал (метр тонн CO₂-экв) хэмжээг тооцоолох;
- Байгалийн нөөцийн хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, нийт хэмнэсэн /дахин боловсруулсан нөөцийн хэмжээг тооцох;
- Хаягдалгүй эдийн засгийн загварыг бий болгох, түүний хүрээнд хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх;
- Хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах технологийг нутагшуулах, хог хаягдлын бүртгэлийг хөтлөж дахин боловсруулах болон дахин ашиглах хогхаягдлын хувь (%)тооцох;
- Аюултай хог хаягдал хэмжээ (цахилгаан хэрэгслийн хог хаягдал ороод) (тонн) бүртгэх, аюултай хог хаягдалтай холбоотой эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах.

НИЙГЭМ

- Ажилтнуудад хяналтын камертай орчинд ажиллах тухай хөдөлмөрийн гэрээ эсвэл ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж, ажилтны зөвшөөрлийг авсан талаар гарын үсгийн баталгаажуулалт авах;
- Бэлгийн дарамтын тухай мэдүүлэх гомдол гаргах үе шат, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажилтнуудад ил харагдах газар байрлуулах;
- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг Олон улсын болон үндэсний стандарт, зөвлөмжүүдэд үндэслэн хийж гүйцэтгэх;
- Аюултай тохиолдлын бүртгэл судалгааг хийж гүйцэтгэх арга, аргачлалыг Олон

улсын арга аргачлалд үндэслэн тодорхойлж, баримтжуулах;

- Ослын статистик тайлан мэдээнд ослын давтамж, ажилласан хүн цагийг тооцож, тогтмол хөтөлж, баримтжуулах;
- Компанийн үйл ажиллагаанаас нийгэмд үзүүлэх нөлөөллийг хэрхэн тогтоох, үнэлэх, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай журам боловсруулж хэрэгжүүлэх;
- Компанийн үйл ажиллагаа тэлэхийн хэрээр шинээр газар авахад байгаль орчин, нийгмийн ямар шалгуураар сонголт хийх, газар чөлөөлөх үйл ажиллагааг хэрхэн зохион байгуудах тухай журам боловсруулж, хэрэгжүүлэх;
- Худалдан авалтын бодлого, журамдаа чанар, хүнсний аюулгүй байдлаар хязгаарлагдалгүй БОНЗ-ын элементийг цогцоор нь тусгаж, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Цаашид өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн засаглалын бодлогыг байгууллагын соёл болон БОНЗ-ын зарчимтай уялдуулан боловсруулж тодорхойлох;
- Үйл ажиллагааны тайланд ТУЗ болон ТУЗ-ийн хороодын тайлан, Компани болон түүний төлөөллийн этгээдтэй холбоотой авлига, хээл хахууль, мөнгө угаалтын бодлогын хэрэгжилт, сургалт, үл нийцэл, олон нийтийн гомдлын статистик үзүүлэлт зэрэг компанийн засаглалтай холбоотой мэдээллийг оруулах;
- Оролцогч талуудын зураглал, дүн шинжилгээг хийж, хамтын ажиллагаа, харилцааны бодлогыг боловсруулан ТУЗ-өөр баталгаажуулан хэрэгжилтийг хангах;
- Бизнесийн тасралтгүй байдал ба хямралын удирдлагын тогтолцоо (Business continuity and crisis management framework) бодлогын баримт бичиг боловсруулж, баталгаажуулж, хэрэгжүүлэх;
- Дотоод хяналт, комплаенсын чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийг тодорхой болгох, чадавхыг бэхжүүлэх;
- Компанийн үйл ажиллагааны удирдлагын болон санхүүгийн тайлагнал, үнэлгээ, хяналтын тогтолцоонд уламжлалт тайлагналын арга хэрэгслүүдээр хязгаарлагдалгүй хөрөнгө оруулагчдын зүгээс тавигдаж буй эрэлт, хэрэгцээг хангахад шаардагдах чадавхыг бий болгохын тулд илүү шинэлэг үнэ цэнд суурилсан соёлыг төлөвшүүлэх;
- Мэдээллийн ил тод байдлыг хангах, хүртээмжийг сайжруулах зорилгоор бодлогын үндсэн баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгох; Тухайлбал:
 - Санхүүгийн зохицуулах хороогоор батлагдсан Компанийн дүрэм,
 - Бизнесийн ёс зүйн дүрэм,
 - Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын бодлого, журмууд

5. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Corporate Finance Institute®
2. Statement of Intent to Work Together Towards Comprehensive Corporate Reporting, Facilitated by the Impact Management Project, World Economic Forum and Deloitte, September, 2020
3. Тайлагналын олон улсын санаачилгын стандартууд
<https://www.globalreporting.org/standards/>
4. Монгол Улсын Үндсэн Хууль
5. Иргэний хууль
6. Компанийн тухай хууль
7. Авлигын эсрэг хууль
8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
11. Нийгмийн даатгалын тухай хууль
12. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
14. Хүнсний тухай хууль
15. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль
16. Автотээврийн тухай хууль
17. Байгууллагын нууцын тухай хууль
18. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
19. Оюуны өмч, патентын тухай хууль
20. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
21. Өрсөлдөөний тухай хууль
22. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
23. Технологи дамжуулах тухай хууль
24. Эрүүл ахуйн тухай хууль
25. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
26. СЗХ: Компанийн засаглалын кодекс
27. СЗХ: Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам
28. СЗХ: Компанийн засаглалыг үнэлэх үнэлгээний асуулга
29. ISO45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандарт
30. ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандарт
31. ОУСК: Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт 1,2,3,4 (2012)
32. НҮБ: Хүний эрхийн түгээмэл тунхаглал
33. [Greenhouse Gases Equivalencies Calculator - Calculations and References | Energy and the Environment | US EPA](#)
34. [ЕХ: Тогтвортой байдлын тайлагналын стандарт](#)
35. [ЕХ: Ногоон таксономи](#)
36. [ТоС Холбоо: Ногоон таксономи](#)